



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/236

Номгон

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн
байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/216, А/235 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 35 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоон ажилласантай холбогдуулан коронавируст халдварын батлагдсан тохиолдлуудын ойрын болон дам хавьтлуудыг урьдчилсан байдлаар тогтоож, гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн мэдээллийг цахим системд шилжүүлэн хяналтыг сайжруулж, голомтын бүс болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 удаа иж бүрнээр хийж эрсдэлийг бууруулсан тул гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг Баянхонгор суманд 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл хэвээр үлдээж, бусад сумдыг хэсэгчилсэн байдлаар бууруулж гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд шилжүүлсүгэй.


2. Баянхонгор сумын гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан тус суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн сумдууд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтийг чанд сахин харьяа нутаг дэвсгэрт зохион байгуулалтын арга хэмжээг сумын Онцгой комиссын хуралдаанаар шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

1210593


2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Заасаг дагтын 2021 оны
04 дүгээр сарын 04-ний өдрийн
А/236 дугаар захирамжийн хавсралт



**БАЯНХОНГОР СУМАНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ**

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж;
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;
3. Шатахуун, түлшний худалдаа, тээвэрлэлт, түгээлт;
4. Хүнсний худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт;
5. Ахуйн хэрэглээний жижиг дунд үйлдвэрлэл
6. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт;
7. Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг ажлын тусгай горимоор 10:00-15:00 цаг хүртэл;
8. Газар тариалан, өвс тэжээлийн нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа;
9. Харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, шуудан илгээмж;
10. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа
11. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа;
12. Тусгай зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагаа;
13. Авто засвар болон дугуй засварын үйл ажиллагаа;
14. Барилга, барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, тээвэрлэлт;
15. Зах, худалдааны төвийн үйл ажиллагаа
16. Буян номын үйл ажиллагаа.